



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 22 дугаар зүйлийн 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 15 дугаар зүйлийн 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Чанд финтех” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Чанд финтех” ХХК /Ө.Мөнхдаваа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН